



Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн систем

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

**ГАРЧИГ
ДУГААР**

ХУУДАСНЫ

1	ТАНИЛЦУУЛГА	4
1.1	БАРИМТ БИЧГИЙН ДУГААР	4
1.2	Зорилго	4
1.3	Үйлчлэх цар хүрээ	4
1.4	Хэрэгжүүлж эхлэх хугацаа	4
1.5	Эрх хэмжээ ба удирдлага	4
2	ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.1	МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.2	БУСАД МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ДАВХЦАХ БАЙДАЛ.....	5
3	ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	5
3.1	МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОЛ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА.....	5
3.2	Голлон хариуцах талууд	6
4	ТӨСЛИЙН СТАНДАРТУУД	6
4.1	Монгол улсын холбогдох хууль тогтоомж	7
4.2	Холбогдох Монгол улсын стандартууд.....	7
4.3	БОНБНУ-ний шаардлагууд.....	8
4.4	Монгол улсын төрийн эрх бүхий байгууллагуудын өмнө хүлээх бусад үүрэг амлалт, тэдгээрээс тавигдах шаардлагууд.....	8
4.5	Холбогдох олон улсын стандарт, удирдамжууд	9
4.6	Холбогдох СЕНТЕРРАГИЙН БОДЛОГУУД.....	9
4.7	Бороо Гоулд Компанийн журмууд.....	9
4.8	Гацууртын дагаж мөрдөх үүрэг хүлээсэн бусад салбарын удирдамжууд.....	9
5	НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ	10
5.1	Хураангуй.....	10
5.2	Төлөвлөгөөний зорилго, зорилтууд	12
5.3	Гол оролцогч талууд.....	12
5.4	МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ	13
6	ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ	17
6.1	МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАХ, ЗАСАЖ САЙЖРУУЛАХ.....	17
7	ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	17
7.1	Хяналт шинжилгээнд тавигдах шаардлагуудын тойм.....	17
7.2	Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд	17
7.3	Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүд	18
8	СУРГАЛТ	20
9	АУДИТ БА ТАЙЛАГНАЛ	20

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1
---	---	-------------

9.1 Дотоод аудит	20
9.2 Гадаад аудит	20
9.3 Бүртгэл хөтлөх	21

Хавсралт А – Гацууртын болон Бороогийн уурхайнуудад ашиглагдах аюултай материалын бүртгэл	22
--	-----------

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1: Хариуцагч ба хариуцлага.....	5
Хүснэгт 2: Менежментийн гол хяналтууд	14
Хүснэгт 3: Аюултай материалын гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд ба хяналт шинжилгээний арга хэмжээнүүд.....	17
Хүснэгт 4: Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүд	19

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Баримт бичгийн дугаар

Энэхүү баримт бичиг нь Гацууртын төслийн (цаашид “Гацуурт” эсвэл “Төсөл” гэх) Аюултай материалын менежментийн төлөвлөгөө юм. Тус баримт бичгийн лавлагаа дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1.

1.2 Зорилго

Сентерра Гоулд Инк (Сентерра) энэхүү Аюултай материалын менежментийн төлөвлөгөөг Гацууртын төсөлд тусгайлан зориулж боловсруулав. Энэ менежментийн төлөвлөгөө нь Сентеррагийн зүгээс өөрийн охин компани нь болох Бороо Гоулд Компаниар (БГК) дамжуулан Гацууртын төслийн байгаль орчны менежментийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлсон багц төлөвлөгөөнүүдийн нэг юм. Тус Менежментийн төлөвлөгөөний ерөнхий зорилго нь:

- Төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, менежментийг хэрэгжүүлэх голлох талуудыг тогтоох;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох ;
- Тус төлөвлөгөөнд баримталбал зохих Төслийн стандартуудыг тодорхойлох;
- Энэ төлөвлөгөөнд хамааралтай төслийн үүрэг амлалт, үйл ажиллагааны журам болон удирдамжуудыг тодорхойлох;
- Хяналт шинжилгээ, тайлагнах журмууд, тэр дундаа гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- Сургалтанд тавигдах шаардлагуудыг тодорхойлох;
- Дагалдах материал, мэдээллийн лавлагааг зааж өгөхөд тус тус оршино.

1.3 Үйлчлэх цар хүрээ

Менежментийн төлөвлөгөөнд заасан шаардлагуудыг Гацууртын бүхий л үйл ажиллагаанд болон нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид дагаж мөрдөнө. Төлөвлөгөөнд заасан шаардлагуудыг Гацуурт дахь олборлолтын үйл ажиллагаа, Бороогийн уурхай дахь хүдрийн тээвэр, хүдэр боловсруулалт зэрэг төсөлд хамааралтай бүхий л үйл ажиллагаанд баримтална.

Энэ менежментийн төлөвлөгөөг Монгол улс дахь Сентеррагийн үйл ажиллагаанд мөрдөх БГК-ийн Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны менежментийн системд (ЭМААБОМС) үндэслэсэн ба Гацууртын төслийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгмийн менежментэд баримтлах ерөнхий бүтцийг хангах юм . БГК-ийн ЭМААБОМС-д ямар нэг нэмэлт өөрчлөлт орвол тус төлөвлөгөөнд мөн өөрчлөлт орохыг үгүйсгэхгүй.

1.4 Хэрэгжүүлж эхлэх хугацаа

Энэ менежментийн төлөвлөгөөг Гацууртын төслийн барилгын үе шатнаас эхлэн мөрдөнө.

1.5 Эрх хэмжээ ба удирдлага

Энэ төлөвлөгөөг БГК-ийн Байгаль орчны асуудал эрхэлсэн захирал хариуцан хэрэгжүүлнэ. Төслийн зураг төсөл, үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй бол энэхүү төлөвлөгөөг хоёр жил тутамд хянаж, шаардлагатай өөрчлөлтийг хийнэ. Менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлтийг төлөвлөгөө хариуцагчид гаргах бөгөөд аливаа өөрчлөлт нь хянах болон батлах зэрэг дарааллаар дамжин шийдвэрлэгдэнэ.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

Менежментийн төлөвлөгөө нь Гацууртын уурхайн барилга, ашиглалт, уурхайн үе шатны үйл ажиллагаа, уурхайн тээвэр, Бороогийн уурхай дахь хүдэр боловсруулалт, мөн гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд хамаарна.

2.2 Бусад менежментийн төлөвлөгөөтэй давхцах байдал

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь БГК-ийн ЭМААБО-ы менежментийн системд тодорхойлогдож, Гацууртын төсөлд зориулан боловсруулагдсан доорх ерөнхий багц менежментийн төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг юм.

- Гадаргын усны менежментийн төлөвлөгөө;
- Хүчиллэг чулуулгын урсацын менежментийн төлөвлөгөө;
- Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө;
- Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө;
- Гацууртын уурхайн хаалтын төлөвлөгөө;
- Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө;
- Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө;
- БГК-ийн Хаягдлын менежментийн байгууламжийн зааварчилгаа;

3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол үүрэг, хариуцлага

Энэхүү төлөвлөгөөг хариуцан хэрэгжүүлэх үүрэгтнүүд ба хариуцлагыг энэ хэсэгт тоймлон үзүүлэв .

Хүснэгт 1: Хариуцагч ба хариуцлага

Хариуцагч	Хариуцлага
БГК-ийн ерөнхий Захирал	Төсөл нь энэ төлөвлөгөөнд заагдсан стандартууд болон бусад шаардлагуудыг мөрдөн ажиллах байдлыг хангуулах. Энэ төлөвлөгөө болон хэрэгжилтэд шаардагдах нөөц хөрөнгийг батлах.
БГК-ийн Байгаль орчны асуудал эрхэлсэн захирал	Төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах. Төлөвлөгөөний боловсруулалт, хяналт шинжилгээ, засвар өөрчлөлтийг хариуцах.
Байгаль орчны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Бусад хэлтсүүд, хэрэгжүүлэгч байгууллагууд, оролцогч талуудын үйл ажиллагааны зохицуулалтын хангаж, төлөвлөгөөг хуваарийн дагуу хэрэгжүүлэх. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

Хариуцагч	Хариуцлага
	Төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагуудын талаар ахлах ажилчид, ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчдийг мэдээлэл, мэдлэг ойлголтоор хангах.
Гэрээт гүйцэтгэгчид	Өөрийн хяналтын дор байгаа бүхий л өмч хөрөнгө, үйл ажиллагаа нь Сентерра болон БГК-ийн бодлого, журмуудад нийцэж байх явдлыг хангах. Холбогдох гэрчилгээ, тусгай зөвшөөрлийнхөө хуулбарыг хууль, журмын дагуу гаргаж өгөх. Байгаль орчны менежментийн талаарх БГК-ийн шаардлагуудыг биелүүлэх. Байгаль орчинд бодитоор учирсан болон учирч болзошгүй бүхий л нөлөөллийн талаар холбогдох ахлах ажилтан эсвэл удирдах албанд мэдээлэх.
Ажиллагсад	Үйл ажиллагаанаас нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг боломжтой тохиолдол бүрт багасгах. Менежментийн төлөвлөгөө болон холбогдох Гацууртын байгаль орчны бодлого, журмуудаад заасан үүргүүдээ биелүүлэх. Байгаль орчинд бодитоор учирсан болон учирч болзошгүй бүхий л нөлөөллийн талаар холбогдох ахлах ажилтан эсвэл удирдах албанд мэдээлэх.

3.2 Голлон хариуцах талууд

Энэхүү менежментийн төлөвлөгөөний холбогдох хэсгүүдийн хэрэгжилтийг дараах хэлтэс нэгжүүд, албан тушаалтнууд голлон хариуцна:

- Үйл ажиллагаа эрхэлсэн ерөнхий менежер нь аюулгүй байдлын менежмент болон уурхайн талбайгаас гадуурх үйл ажиллагааг аюулгүй хэрэгжүүлэх талыг хариуцна;
- Боловсруулах үйлдвэрийн менежер нь БГК-ийн боловсруулах үйлдвэрийн талбай дахь урвалжийн агуулахыг хариуцна;
- Уурхайн менежер нь Гацууртын уурхай дахь түлш шатахуун, тэсэрч дэлбэрэх бодис болон хаягдал тосны хадгалалт, ашиглалтыг хариуцна;
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудал эрхэлсэн захирал нь аюултай материалын менежментийн эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх талыг хариуцна;
- Ложистик буюу материал, техникийн хангамж хариуцсан менежер нь аюултай материалын худалдан авалт болон Бороогийн уурхайн талбай, Гацууртын уурхай руу тээвэрлэх асуудлыг хариуцна;
- Хүний нөөцийн асуудал эрхэлсэн захирал –ажиллах хүчний менежментийг хариуцна.

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

Холбогдох стандартуудыг төслийн бүхий л үйл ажиллагаанд заавал дагаж мөрдөнө (“Төслийн стандартууд”).

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж

АММТ-нд баримталбал зохих холбогдох Монгол улсын хууль тогтоомжууд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995);
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012);
- Усны тухай хууль (2012);
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012);
- Газрын хэвлийн тухай хууль (1988);
- Агаар бохирдлын төлбөрийн тухай хууль (2010);
- Хог хаягдлын тухай хууль (2012);
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2006).

4.2 Холбогдох Монгол улсын стандартууд

АММТ-нд баримталбал зохих холбогдох Монгол улсын стандартууд (MNS):

- MNS 3342:1982 Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Газрын доорхи усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага;
- MNS 2573:1978 Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Усны чанарын үзүүлэлтүүд;
- MNS 900:2005 Байгаль орчин. Хүний эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт;
- MNS 4586:1998 Усны чанар. Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага;
- MNS 4047:1988 Гадаргын усны чанарыг хянах журам;
- MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 5917:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага;
- MNS 3297:1991 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ.

Төсөлд баримталбал зохих аюултай материалтай харьцах талаарх Монгол улсын стандартуудын жагсаалт:

- Аюултай материалын эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын химийн хорт болон аюултай бодисын тухай 2006 оны хуулиар тогтоож өгсөн. Энэ хуулинд химийн хорт бодисын импорт, экспорт, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, хяналтын асуудлуудыг авч үзсэн. Мөн энэ хуулинд хорт болон аюултай бодисоос хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон байдаг. Уурхайн талбайд химийн бодис ашиглахын зэрэгцээ талбай руу болон талбайн орчинд тээвэрлэгдэнэ. Энэхүү Аюултай материалын менежментийн төлөвлөгөө нь тус хуулийг дагаж мөрдөхөд дөхөм болгох зорилготой юм;
- Ариун цэврийн тухай хууль (1998.7.1-нд хүчин төгөлдөр болсон). Нийтийн эрүүл мэндийн тухай уг хуулийн зорилго нь хувь хүмүүсийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах эрхийг бататгах, энэ талын хувь хүмүүс болон бизнесийнхний эрх, үүргийг тодорхойлоход оршино. Химийн хорт бодис ашиглалтын асуудлыг шийдэх зохицуулалтанд заасны дагуу хэрэгжүүлэх химийн

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа:
2016.06.06

Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

бодисын ашиглалттай холбоотой үйл ажиллагааны шаардлагыг энэ хуулинд багтаасан. Бизнесийн байгууллагууд ажиллагсадаа сургалтанд хамруулах зэргээр ажлын байрны аюулгүй орчныг хангах үүрэгтэй.

- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам (*Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад хэргийн сайд нарын 334/104 тоот хамтарсан тушаалын хавсралт*);
- Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам (*Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 28/40/29 тоот хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт*);
- Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээний журам (*Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт*);
- Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт, Засгийн газрын 2007 оны 95-р тоот тогтоол.

4.3 БОНБНУ-ний шаардлагууд

Энэхүү төсөлд зориулан хийсэн Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнүүдэд (БОНБНУ) байгаль орчны менежмент, хяналтад тавигдах шаардлагуудыг тоймлон тусгасан. Дараах БОНБНУ-нүүдэд тусгагдсан үүрэг амлалтууд тус МТ-нд хамаарна. Үүнд:

- БИОИСЭЛДҮҮЛЭЛТИЙН® үйлдвэрийн БОНБНУ (*Натур Фрейндли ХХК, 2010*);
- Гацууртын тээврийн замын БОНБНУ (*Газар Эко, 2006*);
- Гацууртын уурхайн БОНБНУ (*Натур Фрейндли ХХК, 2009*);
- Бороогийн алтны уурхайн БОНБНУ-ний нэмэлт тодотгол (*Натур Капитал, 2015*).

4.4 Монгол улсын төрийн эрх бүхий байгууллагуудын өмнө хүлээх бусад үүрэг амлалт, тэдгээрээс тавигдах шаардлагууд

Монгол улс олон улсын хэд хэдэн гэрээ, хэлэлцээрт нэгдэж, тэдгээрт заагдсаны үүрэг хүлээсэн байдаг. Монгол улс олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх хуулиудыг соёрхон баталсан ба Монгол Улсын гарын үсэг зурж баталсан олон улсын гэрээнүүдтэй үндэсний хуулиуд нийцэхгүй байгаа тохиолдолд олон улсын гэрээний шаардлагуудыг дагаж мөрдөх заалтуудыг оруулсан байдаг. Тиймээс эдгээр Монгол улсын нэгдсэн олон улсын гэрээний нөхцлүүдийг ойлгох хэрэгтэй байгаа юм. Гацууртын төсөлд аюултай материалтай харьцах, ашиглахад баримталбал зохих олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн товч хураангуйг дор тусгав.

Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц (*Монгол улсад 2001.3.8-нд хүчин төгөлдөр болсон*)

Энэхүү конвенц нь нэгдэн орсон талуудын эрүүл мэнд эсвэл байгаль орчны холбогдолтой шалтгаанаар хориглосон эсвэл эрс хязгаарласан пестицид болон аж үйлдвэрлэлийн химийн бодисын талаарх зүйл заалтуудыг хамрах ба талууд Урьдчилан мэдээлж зөвшилцөх журамд оруулахаар мэдэгдсэн байдаг. Уг журмын дагуу бүх талууд тодорхой нэр заасан химийн бодисуудыг цаашид импортлоход санал нийлэх эсэхэд мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломжтой болдог.

Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц (*Монгол улсад 2004.4.30-нд хүчин төгөлдөр болсон*)

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

Энэхүү олон улсын хэлэлцээрийн зорилго нь байгаль орчинд удаан хугацаагаар задралгүй үлддэг, үүссэн газраасаа өргөн уудам газар нутагт тархдаг, хүн болон зэрлэг амьтанд био хуримтлал үүсгэдэг химийн бодисуудаас хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад оршино.

4.5 Холбогдох олон улсын стандарт, удирдамжууд

Олон улсын стандартчлалын байгууллагаас байгаль орчин, ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежментийн тухай өргөн хүрээтэй хүлээн зөвшөөрөгдсөн цуврал стандартуудыг баталсан билээ.

- ISO 14001:2004 Байгаль орчны менежментийн системийн стандарт
- OHSAS¹ 18001 Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежментийн системийн стандарт.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) 2014 оны Байгаль орчин, нийгмийн бодлогод заасны дагуу Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон хяналт шинжилгээний үйл явцаараа дамжуулан санхүүжүүлж буй төслүүдэд дараах шаардлагуудыг хангасан байх явдлыг бататгахыг эрмэлзэж ажилладаг. Үүнд:

- Байгаль орчин, нийгмийн талаараа тогтвортой байх;
- Нөлөөлөлд өртсөн ажиллагсад болон орон нутгийн иргэдийн эрхийг дээдлэх;
- Үйл ажиллагаа нь холбогдох хуулийн эрх зүйн шаардлагууд, олон улсын сайн туршлагад нийцэж төлөвлөгдөх, явагдах.

ЕСБХБ-ны холбогдох Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн шаардлагууд:

- Гүйцэтгэлийн шаардлага 1: Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлын үнэлгээ ба менежмент;
- Гүйцэтгэлийн шаардлага 3: Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах.

ЕСБХБ санхүүжүүлсэн төслүүдээ аюултай материалын менежментэд тусгайлан хамаарах доорх зүйлсийг багтаасан Европын байгаль орчны зарчмуудыг дагаж мөрдөхийг шаарддаг. Үүнд:

- Тогтоол ЕК 1907/2006: Химийн бодисын бүртгэл, үнэлгээ, хязгаарлалтын тухай;
- Удирдамж 2003/105/ЕК: Аюултай бодисоос шалтгаалах томоохон аюулын тухай;
- Удирдамж 2008/1/ЕК: Аж үйлдвэрлэлийн бохирдлоос сэргийлэх, хянах тухай;
- Удирдамж 89/391/ЕЕК: Ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тухай.

4.6 Холбогдох Сентеррагийн бодлогууд

Энэ менежментийн төлөвлөгөө нь Сентеррагийн корпорацийн бодлогын хүрээнд боловсруулагдсан ба үүнд ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хамгаалах болон тогтвортой хөгжлийн бодлогуудыг багтаасан.

4.7 Бороо Гоулд Компанийн журмууд

Сентеррагийн бүхий л үйл ажиллагаа нь Бороогийн уурхайд хэрэгжүүлэх БГК-ийн ЭМААБОМС-ийн шаардлагуудын хүрээнд хэрэгжих ба Аюултай материалтай харьцах, хадгалах журам нь менежментийн системийн бүрэлдэхүүнд ордог. Тус журам энэхүү менежментийн төлөвлөгөөнд тусгасан зорилтууд болон хяналтын арга хэмжээнүүдтэй нийцэж байгаа болно.

4.8 Гацууртын дагаж мөрдөх үүрэг хүлээсэн бусад салбарын удирдамжууд

¹ Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны үнэлгээний цуврал стандарт

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

Сентерра нь алт олборлох үйл явцад цианид үйлдвэрлэх, тээвэрлэх, ашиглахад баримтлах Олон улсын цианидын менежментийн Код-д гарын үсэг зурж нэгдэн орсон билээ. Тус Код-д дор дурдсан асуудлуудад тусгайлан хамааралтай арга хэмжээнүүд багтана. Үүнд:

- Хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн арга барилаар цианидыг нийлүүлэх, тээвэрлэх;
- Алт олборлолтод ашиглах зориулалттай цианидыг хариуцлагатай ашиглах, хадгалах;
- Цианид ашиглалтыг багасгах үүднээс цианидын нэмэлт хэрэглээг оновчтой болгох;
- Ажиллагсдыг цианидын хор хөнөөлтэй нөлөөллөөс хамгаалах арга хэмжээ;
- Цианид байгаль орчинд санаандгүй алдагдах эрсдэлийг багасгах, хор хөнөөлд нь ажиллагсад болон олон нийт өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Зэрлэг амьтдыг алтны уурхайнууд дахь ил задгай боловсруулалтын усны цианидын хор хөнөөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Бохир ус болон уурхайн хаягдлыг зайлуулахдаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх явдлыг бататгах шаардлагууд.

5 НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ

5.1 Хураангуй

Гацууртын төслийн үйт ажиллагаанаас шууд ба шууд бусаар үүсч болзошгүй Аюултай материалын эрсдэлүүдийг бууруулах талаарх Гацууртын хүлээсэн үүрэг, аргачлалыг энэхүү баримт бичигт тоймлон тусгав.

Тус Менежментийн төлөвлөгөөний зорилго нь Гацууртын төсөлд аюултай материалыг аюулгүй болон зүй зохистой тээвэрлэх, харьцах, ашиглах, хадгалах замаар аюултай материалын менежментийг зөв зохистой гүйцэтгэх явдлыг хангахад оршино. Монгол улсын болоод олон улсын холбогдох стандартуудын дагуу аюултай материалтай холбоотой эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны эрсдэлүүдийг багасгахад чиглэсэн менежментийн хяналтыг хэрэгжүүлэх арга замаар энэ зорилгодоо хүрнэ. Аюултай материалын агуулахын зураг төслийг гаргах, түүний засвар үйлчилгээг тухайн байгууламжуудад тусгайлан чиглэсэн хууль ёсны зөвшөрөл болон зөвшөөрөл авах шаардлагуудад заасны дагуу хийх ба Монгол улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагууд тогтмол үзлэг шалгалтыг хийнэ.

Төслийн алт олборлох үйл явцад аюултай шинж чанартай олон төрлийн урвалжуудыг ашиглах шаардлагатай ба үүнд цианид, хүчил, идэмхий бодис, тэсэрч дэлбэрэх бодис, гидрокарбонат зэрэг химийн бодисууд багтана. Бороогийн уурхай болон Гацууртын төсөлд ямар нэг үед ашиглагдаж магадгүй химийн бодисуудын жагсаалтыг хавсралт А-д харуулав.

Тус менежментийн төлөвлөгөө нь Гацуурт дахь аюултай материалын менежментийн өдөр тутмын үйл ажиллагааны тодорхой асуудлуудыг илүү дэлгэрэнгүй үзүүлсэн доорх багц баримт бичгүүдээр дэмжигдэн хэрэгжинэ. Эдгээр баримт бичгийг Гацууртын төслийн барилга, ашиглалтын шат эхлэхээс өмнө боловсруулна.

БГК-ийн ЭМААБОМС-д Аюултай материалтай харьцах, хадгалах журам болон тэдгээр материалтай харьцах үед ажиллагсдын аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хамгаалах хамгийн наад захын стандарт, шаардлагууд ба уурхайн талбайд хадгалахад тавигдах шаардлагуудыг дэлгэрэнгүй заасан бусад журмууд ордог. Эдгээр журмыг Гацууртын уурхайн барилга ба ашиглалтын үе шат, Бороод шинээр хийгдэх ажлууд болон тээврийн зам дагуух үйл ажиллагаануудыг тусгах үүднээс шинэчлэн сайжруулна. Одоогийн байгаа журмуудад гол шинэчлэл, өөрчлөлт оруулах шаардлагатай зүйлсийг дор тодорхойлов:

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа:
2016.06.06

Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

- Дор дурдсан зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан Аюултай материалтай харьцах, хадгалах журам :
 - Төсөлд ашиглагдах аюултай материалуудыг тодорхойлох;
 - Гацууртын төсөлд хадгалагдаж, ашиглагдаж байгаа бүх аюултай материалд эрсдэлийн үнэлгээ хийх, зөвшөөрөл олгох үйл явц;
 - Давхар хамгаалалттай аюултай материал хадгалах байгууламжуудын тохирох зураг төсөл, барилга байгуулалт;
 - Төслийн талбайгаас болон талбай руу аюултай материал тээвэрлэх журам;
 - Аюултай материалын байгууламжуудын ашиглалаас гаргах журам;
- Аюултай материал, бодис ашиглах зөвшөөрөл – уурхайн талбайд ашиглах химийн бодисуудад тавигдах шаардлагатай хяналтын арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгах зорилгоор одоогийн журмуудад нэмэлт өөрчлөлт оруулна. Зөвшөөрөл олгох үйл явц нь ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчид уурхайн талбайд зөвхөн зөвшөөрөгдсөн химийн бодис ашиглах, тээвэрлэх, хадгалах явдлыг бататгахад зорино.
- Тэсэлгээний менежментийн журам – Гацуурт дахь уурхайн үйл ажиллагаанд ашиглах тэсэрч дэлбэрэх бодистой аюулгүй харьцах, хадгалах асуудлыг тусгах үүднээс нэмж оруулна.
- Бодис асгарах тохиолдолд хариу арга хэмжээ авах журам – гидрокарбонат гэх мэт химийн бодис алдагдахад анхны хариу арга хэмжээ авах дэлгэрэнгүй мэдээллээр хангах болон бодис асгарсан тохиолдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учрах эрсдэлээс зайлсхийх, багасгах арга хэмжээг бататгах зорилгоор шинэчилнэ. Хариу арга хэмжээ авах журмуудад дараах багтана:
 - Аюултай материалыг тараахгүй тогтоон барих, асгаралтын цар хэмжээг багасгах яаралтай залруулах арга хэмжээнүүд. Үүнд мөн суваг шуудуу руу асгаралт хальж орохоос сэргийлэх зэрэг арга хэмжээ орно;
 - Цианид, хүчил, идэмхий бодис, гидрокарбонат гэх мэт бодис асгарах тохиолдолд тухайн бодисод тохирсон хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 - Бодис асгарах тохиолдлын улмаас эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд учрах аюулаас хамгаалах хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон бусад аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүд. Осол зөрчлийг заасны дагуу бүртгэж, тайлагнана. Тайланд хамгийн багадаа дараах мэдээллийг дэлгэрэнгүй тусгана. Үүнд:
 - Асгарсан бодисыг цэвэрлэх арга хэмжээнүүд, үүнд асгарсан материалыг зайлуулах, цэвэрлэн арилгах журмууд, хөрс, уснаас дээж авах, боломжтой тохиолдолд саармагжуулах хэрэгсэл ашиглах;
 - Осол зөрчлийн тохиолдлыг бүртгэх, тайлагнах зааварчилгаа;
 - Залруулгын арга хэмжээнүүдийг тодорхойлох, осол зөрчлийн мөрөөр үзлэг шалгалт хийх түүнчлэн байгаль орчин ба хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийг хянаж шинжлэх зэрэг дараагийн шатны арга хэмжээнүүдийг гүйцэтгэх.
- Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө – Бороогийн уурхайн онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг Гацууртын уурхай дахь үйл ажиллагаа, нэмэлт аюултай материалууд, Гацуурт дахь олборлолт болон Бороогийн уурхай дээр шинээр бий болох боловсруулах байууламжуудаас үүсэх тээвэрлэлтийн болон хадгалалтын эрсдэлүүдийг зохицуулах арга, үйл ажиллагааг хамруулан өргөжүүлнэ. Энэхүү төлөвлөгөөний (ОБҮААХТ) зорилго нь төсөл болон байгаль орчинтой холбоотой бүтэц зохион байгуулалтын хариуцлага, арга хэмжээ, тайлагнах шаардлагууд, төсөл болон хүрээлэн буй орчинтой холбоотой онцгой байдлын нөхцөлд (*жишээ нь, аюултай химийн бодис алдагдах*) зохион байгуулалттай, цаг алдалгүй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд нөлөөлөх дотоод болох гадаад боломжит нөөц бололцоог тодорхойлоход оршино. Тус төлөвлөгөөнд дор дурдсан арга замаар зохион байгуулалттай, үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ багтсан болно. Үүнд:

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа:
2016.06.06

Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

- Онцгой байдлын үед авах арга хэмжээний ерөнхий үйл явц болон уялдан холбогдох талуудыг баримтжуулах;
- Тохиолдож болзошгүй бүхий л онцгой байдлын хувилбаруудыг тодорхойлох;
- Онцгой байдлын үед баримтлах журмуудыг тодорхойлох;
- Онцгой байдал тохиолдох үед гэрээт туслан гүйцэтгэгчдийг хамруулан ажиллагсдын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- Онцгой байдлын талаар мэдээлэх, тайлагнах.

Дээр тайлбарласан журмуудаас гадна, энэхүү Аюултай материалын менежментийн төлөвлөгөөг тухайн үеийн шаардлагын дагуу дэмжин хэрэгжих өөр бусад журмуудыг боловсруулж болно.

Гацууртын үйл ажиллагаанд мөрдлөг болгох гол менежментийн хяналтуудыг Хүснэгт 2-т үзүүлэв. Эдгээр хяналтуудыг тохирох журмуудаар (*аюултай материалд зөвшөөрөл олгох гэх мэт*) эсвэл стандарт ажлын арга барилууд (*аюултай материал хадгалах гэх мэт*) дамжуулан хэрэгжүүлнэ.

5.2 Төлөвлөгөөний зорилго, зорилтууд

Аюултай материалын менежментийн ерөнхий зорилт нь аюултай материалыг үйлдвэрлэх, харьцах, хадгалах, ашиглах үед хяналтгүйгээр бодис алдагдах эсвэл дэлбэрэлт, гал түймэр зэрэг осол гарахаас зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд багасгахад оршино. Эл зорилтонд дор дурдсан арга замаар хүрнэ:

- Эрсдэлд суурилсан аюултай материалын менежментийн эрэмбийг тодорхойлох;
- Аюултай материалын хэрэглээнээс зайлсхийх эсвэл багасгах;
- Байгаль орчинд хяналтгүй бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх;
- Агуулах, хадгалалтын инженерийн хяналтуудыг авч хэрэгжүүлэх;
- Үлдэгдэл эрсдэлийг арилгах менежментийн хяналтуудыг хэрэгжүүлэх;
- Осол зөрчил гарсан үед зохих эрсдэлд суурилсан онцгой байдлын менежментийн журам бэлэн байх явдлыг бататгах.

Энэхүү Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар эдгээр зорилтуудаа биелүүлэх ба 7.2 дахь хэсэгт дэлгэрэнгүй тусгасан Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хэмжиж, үнэлнэ.

5.3 Гол оролцогч талууд

Энэхүү менежментийн төлөвлөгөөнд хамаарал бүхий гол оролцогч талууд:

Оролцогч тал	Хамрах/харилцан ажиллах сэдэв
Байгаль орчны хэлтэс	Аюултай материал хадгалах байгууламжуудад үзлэг шалгалт хийх; Төлөвлөгөөний биелэлтийг хянах; аюултай материалын менежментийн арга туршлагын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх; шинэ аюултай материал болон агуулах байгууламжуудын зөвшөөрөл, баталгааг зохион байгуулах.
Боловсруулалтын хэлтэс	Бутлалт, нунтаглалтын урвалжуудыг баримтжуулах болон бүртгэх; сургалтын материал боловсруулахад оролцох; сургалт хийх; инженерийн төлөвлөгөөг хянах, батлах.
Засвар, үйлчилгээний хэлтэс	Засвар, үйлчилгээний химийн бодисуудын бүртгэл, баримтжуулалт; сургалт хийх.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2016.06.06	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

Оролцогч тал	Хамрах/харилцан ажиллах сэдэв
Олон Улсын Цианидын Менежментийн Институт	Олон улсын цианидын менежментийн кодын биелэлтийг баталгаажуулах
Монгол улсын Засгийн газар	Аюултай материал ашиглах, хадгалах, тээвэрлэх зөвшөөрөл олгох; зөвшөөрлийн шаардлагуудын биелэлтэд тогтмол давтамжтайгаар хяналт шалгалт хийх.

5.4 Менежментийн хяналт

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд тодорхойлогдсон нөлөөллүүд, бууруулах боломжуудад үндэслэн Гацууртын уурхайн барилга, ашиглалт, хаалтын үе шатуудад хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээнүүдийг хүснэгт 2-т дэлгэрэнгүй үзүүлэв.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа:
06.06.2016

Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

Хүснэгт 2: Менежментийн гол хяналтууд

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэглээ, үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах талууд	Гүйцэтгэлийн шалгуур
AM01	Материалын үнэлгээ, сонголт	Бүх аюултай материалыг сонгох	Бүх аюултай материалд Химийн бодисын БОНБНҮ болон Гацууртын удирдамжуудад заасан шаардлагуудын дагуу үнэлгээ хийнэ. Уг үнэлгээг холбогдох чиглэлээр мэргэшсэн, туршлагатай мэргэжилтэн гүйцэтгэх ба ЭМААБО-ы хэлтсээр батлуулна.	<ul style="list-style-type: none"> • ЭМААБО-ы хэлтэс • Худалдан авалт • Үйл ажиллагааны хэлтсүүд • Үндсэн гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> • Химийн бодис, аюултай материалын бүртгэл, тэмдэглэл • Аудит ба үзлэг шалгалт
AM02	Аюултай материалын бүртгэл	Аюултай материалын хадгалалт	Хадгалж буй бүх материалын Хор аюулын лавлах материалыг (ХАЛМ) Монгол, Англи хэл дээр, шаардлагатай бол өөр ямар нэгэн хэл дээр бэлдэж хангана. Эдгээр мэдээллийг тухайн материалыг хадгалах байршлууд, ашиглалтын гол цэгүүдэд бэлэн байлгана.	<ul style="list-style-type: none"> • ЭМААБО-ы хэлтэс • Үндсэн гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> • Дотоодын аудитын хөтөлбөр болон бүртгэл • Хадгалах байрнуудад ХАЛМ-ыг байгааг нүдээр харж баталгаажуулах • Химийн бодис, аюултай материалын бүртгэл, тэмдэглэл
AM03	Хадгалах журмууд	Аюултай материалын хадгалалт	Аюултай шингэн материал (<i>хаягдал тос, уусгагч бодис зэрэг</i>) хадгалалтыг 120%-ийн багтаамжтай шүүрэлт багатай давхар агуулахаар хангана.	<ul style="list-style-type: none"> • ЭМААБО-ы хэлтэс • Үйл ажиллагааны хэлтсүүд • Үндсэн гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> • Дотоод аудитын хөтөлбөр • Нүдээр үзэж шалгах • Барилга угсралтын зураг төслийн дараах баталгаа, магадлагаа
AM04	Хадгалах журмууд	Аюултай материалын хадгалалт	Газар доорхи ус шавхуурганд хаягдал тос удаан хугацаанд хадгалахгүй байх; төмөр савнууд болон ус шавхуургуудыг тогтмол хоослон, үзлэг хийж ан цав, нүх сүв гарсан шинж тэмдэг байгаа эсэхийг тогтмол шалгана. Үзлэг шалгалтын дүгнэлийг бүртгэнэ; ямар нэг ан цав, нүх сүв	<ul style="list-style-type: none"> • ЭМААБО-ы хэлтэс • Үйл ажиллагааны хэлтсүүд • Үндсэн гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> • Дотоод аудитын хөтөлбөр • Нүдээр үзэж шалгах

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа:
06.06.2016

Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэглээ, үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах талууд	Гүйцэтгэлийн шалгуур
			гарсан байвал засварлах ба хийсэн аливаа засварыг бүртгэж, тэмдэглэнэ.		
AM05	Хадгалах журмууд	Аюултай материалын хадгалалт	Асгаралтын иж бүрдэл, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, галын хор зэрэг зайлшгүй шаардагдах төхөөрөмжийг уурхайн талбайд аюултай материалтай харьцдаг, байршдаг хэсгүүдэд асгарсан бодисыг цэвэрлэх, гал түймрийг утраахад бэлэн байлгана.	<ul style="list-style-type: none"> ЭМААБО-ы хэлтэс Үйл ажиллагааны хэлтсүүд Үндсэн гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> Дотоод аудитын хөтөлбөр Нүдээр үзэж шалгах
AM06	Хадгалах журмууд	Аюултай материалын хадгалалт	Нүд угаах, зайлах шингэн гэх мэт зохих анхны тусламжын иж бүрдэлийг аюултай материал хадгалах газруудад ойрхон байршуулна.	<ul style="list-style-type: none"> ЭМААБО-ы хэлтэс Үйл ажиллагааны хэлтсүүд Үндсэн гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> Дотоод аудит, үзлэг шалгалтын хөтөлбөр
AM07	Аюултай материал тээвэрлэх (ерөнхий)	Аюултай материалын тээвэрлэлт	Аюултай материалыг зөвхөн тусгай зөвшөөрөлтэй ба/эсвэл тухайн материалыг тээвэрлэх зөвшөөрлийг Гацууртаас авсан операторууд/ жолооч нар тээвэрлэнэ.	<ul style="list-style-type: none"> ЭМААБО-ы хэлтэс Үндсэн гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> Дотоод аудитын хөтөлбөр Нүдээр үзэж шалгах Хүргэлтийн бүртгэл
AM08	Цианидын менежмент	Цианидын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт	Гацууртын төслийн барилга, ашиглалтын үйл ажиллагаанд ОУЦМИ-ийн Цианидын кодыг бүрэн дагаж мөрдөнө.	<ul style="list-style-type: none"> Боловсруулалтын хэлтэс ЭМААБО-ы хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Гуравдагч байгууллагаар шалган магадлуулах, ОУЦМИ-ийн нийтийн жагсаалт бүртгэгдсэн байх.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөөХэрэгжүүлж эхлэх хугацаа:
06.06.2016Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Хэрэглээ, үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах талууд	Гүйцэтгэлийн шалгуур
AM09	Гидрокарбон атын менежмент	Түлш шатахуун цэнэглэлт болон засвар, үйлчилгээ явагдах талбайнууд	Тээврийн хэрэгслийн түлш шатахуун цэнэглэх бүх талбай болон засвар, үйлчилгээний цехүүдийг тусгай зориулалтын суваг шуудуу, шавхуургатай асгаралт, гоожилтыг агуулж, цуглуулдаг шүүрэлт багатай, хатуу хучилттай газар байршуулна. Хатуу хучилттай талбай нь зохих зураг төслийн стандартад заасны дагуу борооны усанд тэсвэртэй, ус агуулах зориулалттай байна.	<ul style="list-style-type: none">• Засвар, үйлчилгээний хэлтэс• Олборлолтын хэлтэс	<ul style="list-style-type: none">• Тоног төхөөрөмжийн түлш шатахуун цэнэглэх, засвар, үйлчилгээний ажил хийх үед байгаль орчинд гидрокарбонат алдагдахгүй байх.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 06.06.2016	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

6 ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ

6.1 Менежментийн төлөвлөгөөг хянах, засаж сайжруулах

Менежментийн төлөвлөгөөг жил бүр хянах ба Гацууртын нөхцөл байдлын өөрчлөлт, үйл ажиллагааны хэрэгцээг тусгах шаардлагатай засвар, шинэчлэлийг хийнэ. Энэхүү төлөвлөгөөг хянан шинэчлэх нь төлөвлөгөөг хариуцан ажилладаг БГК-ийн Байгаль орчны асуудал эрхэлсэн захирлын үүрэг хариуцлага мөн.

Үйл ажиллагааны журмуудад өөрчлөлт оруулах шаардлага үүсвэл (*Гацууртын Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны (ЭМААБО) менежментийн системд орсон Өөрчлөлтийн менежментийн журмуудын дагуу тодорхойлсончлон*) энэ менежментийн төлөвлөгөөг шаардлагатай тохиолдолд шинэчилж болно.

Менежментийн төлөвлөгөөг хянаж шинэчлэх бүрдээ Гацууртын нийт ажилчин, албан хаагчдыг энэ төлөвлөгөөний хамгийн сүүлийн хувилбартай танилцах боломжоор хангах үүднээс тухайн шинэчлэгдсэн хувилбарыг Сентеррагийн баримт бичгийн менежментийн системд байршуулна.

7 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

7.1 Хяналт шинжилгээнд тавигдах шаардлагуудын тойм

Энэ хэсэгт төслийн стандартуудын биелэлтэд үнэлгээ хийх, ашиглалтын шатанд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний арга хэмжээнүүдийг тодорхойлов (*"Төслийн стандартууд" гарчигтай 4-р бүлгийг үзнэ үү*).

Төслийн стандартууд зөрчигдөж байгаа нь хяналт шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд түүний мөрөөр үзлэг шалгалт хийж, зохих засаж залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

7.2 Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд

Доорх хүснэгтэд гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд, мөн төлөвлөж буй нөлөөллийг бууруулах стратегүүдийн ахиц дэвшил, үр дүнг үнэлэхэд ашиглагдаж болох холбогдох гол хяналт шинжилгээний арга хэмжээнүүдийг хураангуйлан үзүүлэв.

Хүснэгт 3: Аюултай материалын гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд ба хяналт шинжилгээний арга хэмжээнүүд

Лавлах дугаар	Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлт	Зорилт	Хяналт шинжилгээний арга хэмжээ
АМ-ГҮШҮ 01	Энэ менежментийн төлөвлөгөөнд тодорхойлогдсон нөлөөллийг бууруулах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлээгүй зөрчлийн тоо.	Зорилт: Тэг Зөрчлийн тоог бууруулах, хэрэгжилтийг сайжруулах	Дотоод аудитын үр дүн

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 06.06.2016	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-NMP-Ver. 1	Хувилбар: 1

Лавлах дугаар	Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлт	Зорилт	Хяналт шинжилгээний арга хэмжээ
АМ- ГҮШҮ 02	Хүн болон байгаль орчинд бодитоор эсвэл хор хөнөөл учруулж болзошгүй тохиолдолд хүргэсэн аюултай материалын алдагдлын осол зөрчлийн мэдээлэгдсэн тоо	Зорилт: Тэг Багасгах болон мэдээлэгдсэн осол зөрчлийн тооны бууралтад үргэлжлүүлэн сайжруулалт гарах	Осол зөрчлийн мэдээллийн бүртгэл
АМ- ГҮШҮ 03	Асгарсан аюултай материалыг цэвэрлэх зэрэг арга хэмжээ авах хугацаа	Зорилт: хүний эрүүл мэнд ба байгаль орчинд эрсдэл учруулах бүх асгаралтын тохиолдлын талаар 24 цагийн дотор мэдээлэгдэж, хариу арга хэмжээ авагдана.	Осол зөрчлийн мэдээллийн мөрөөр авсан хариу арга хэмжээний бүртгэл Осол зөрчлийн товч танилцуулгын бүртгэл
АМ- ГҮШҮ 04	Гацууртын үйл ажиллагааг ОУЦМИ-ийн Цианидын кодоод бүрэн нийцүүлж хэрэгжүүлнэ.	Боловсруулалтын шинэ байгууламжуудыг ашиглалтанд оруулснаас хойш 12 сарын дотор Гацууртын үйл ажиллагааны бүрэн баталгаажуулалтанд хүрэх.	Гуравдагч байгууллагаас шалган магадлах аудит.

7.3 Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүд

Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүд нь аюултай материалыг хадгалах, агуулах байгууламжуудыг төлөвлөх болон ашиглахад төвлөрөх ба БГК-ийн ЭМААБОМС-ийн дотоод аудит, үзлэг шалгалтын хөтөлбөрөөр дамжин хэрэгжигдэнэ. Аюултай материалтай холбоотой осол зөрчлийг ЭМААБОМС-ийн осол зөрчлийн статистикийн хяналтаар дамжуулан хянаж шинжлэнэ. Онцгой байдлын үед болон бодис асгарах тохиолдолд авах арга хэмжээний бэлэн байдлын хяналт шинжилгээг асгаралтын үед авах арга хэмжээний дасгал сургуулилалтын бүртгэлээр дамжуулан хийнэ.

Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүдийг дор үзүүлэв.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 06.06.2016	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-NMP-Ver. 1	Хувилбар: 1

Хүснэгт 4: Хяналт шинжилгээний гол арга хэмжээнүүд

Лавлах дугаар	Хамрах сэдэв, асуудал	Үзүүлэлтүүд	Арга зүй	Давтамж	Байршил
AM001	Аюултай материалын бүртгэл	Аюултай материалын хэмжээ	Гацуурт нь худалдаж авсан, хүргэгдэж ирсэн, хадгалж, ашиглаж байгаа бүх аюултай материалын бүртгэлийг хадгална.	Сар бүр шинэчилнэ	Тусгайлан заагаагүй
AM002	Аюултай материалтай харьцах	Төрөл бүрийн	Гацуурт нь дараах зүйлсийн аюултай бодисын бүртгэлийг цуглуулж, хадгална. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Нэгдсэн бүртгэл; • Долоо хоног тутмын ашиглалтын хураангуй; • Хадгалах талбай бүрийн долоо хоног тутмын бүртгэлийг нэгтгэх; • Халилт, асгаралтын дохиоллыг турших; • Даралтын туршилт (<i>хамааралтай бол</i>); • Хадгалалтын төмөр савны систем, хоолой болон хүргэлтийн системд үзлэг шалгалт, засвар, үйлчилгээний шалгалт хийх; • Системд ямар нэг өөрчлөлт хийх; • Гоожих, алдагдах тохиолдлын тайлан мэдээлэл; • Бодис асгарах, халих үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан. 	Долоо хоног бүр /янз бүр	Тусгайлан заагаагүй
AM003	Аюултай материалтай харьцах, хадгалах	Агуулахаас бодис алдагдах, асгарах, тохиолдол	Осол зөрчлийн талаарх тайлангуудыг ЭМААБОМС-ээр дамжуулан хянах	Сар бүр	Тусгайлан заагаагүй
AM004	Аюултай материалтай харьцах, хадгалах	Онцгой байдлын үед авах арга хэмжээний бэлэн байдал	Осол зөрчлийн үед авах арга хэмжээний дасгал сургуулилалтын талаар товч тайлангуудыг гүйцэтгэх, хянах	Жил бүр	Тусгайлан заагаагүй
AM005	Цианидын менежмент	ОУЦМИ-ийн Кодын нийцэл	Гуравдагч байгууллагаар шалган магадлах аудит	3 жилд нэг удаа	Бороогийн уурхайн боловсруулах байгууламжууд

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 06.06.2016	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

8 СУРГАЛТ

Сентеррагийн бүх ажиллагсад болон Гацууртын төсөлд шалгаруулалтаар сонгогдсон гэрээт гүйцэтгэгчид аюултай материалын менежментийн үндсэн сургалтад хамрагдах шаардлагатай. Дор дурдсан ажилтнуудыг нэмэлт сургалтаар хангаж мэргэжүүлнэ. Үүнд:

- Онцгой байдлын үед арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажиллагсдыг аюултай материал асгарах, химийн бодисоос гал түймэр гарах, хий алдагдах тохиолдолд арга хэмжээ авч хэрэгжүүлэх, анхны тусламж үзүүлэх, бохирдолыг цэвэрлэх чиглэлээр;
- Боловсруулах үйлдвэрийн ажиллагсдыг тусгайлан цианид гэх мэт урвалжтай харьцах, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл хэрэглэх, анхны тусламж үзүүлэх, хий хянах багаж ашиглах чиглэлийн сургалтаар;
- Байгаль орчны ажиллагсдыг аюултай материал асгарах, халих тохиолдолд хариу арга хэмжээ авах, цэвэрлэх, бохирдолгүй болгох, нөхөн сэргээх, хөрс болон газрын доорх усанд тогтмол хяналт шинжилгээ хийх сургалтаар;
- Олборлолт, засвар үйлчилгээний ажиллагсдыг түлш шатахуун, тостой харьцах, асгарсан гидрокарбонат цэвэрлэх ажиллагаанд сургалтаар;
- Тэсэлгээний ажилд оролцох уурхайн ажиллагсад тэсэрч дэлбэрэх бодистой харьцах чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн байна;
- Бүх ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчдийг аюултай материалын талаар мэдээлэлтэй байх, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл хэрэглэх, осол зөрчлийн талаар мэдээлэх чиглэлээр сургалтад хамруулсан байна;
- Химийн бодис нийлүүлэгч, жолооч нар химийн бодис тээвэрлэх, осол зөрчлийн үед хариу арга хэмжээ авах, анхны тусламж үзүүлэх чиглэлээр албан ёсны сургалтад хамрагдаж, итгэмжлэгдсэн байна.

Хамрагдсан бүх сургалтын бүртгэл, мэдээллийг хөтөлж, хадгална.

9 АУДИТ БА ТАЙЛАГНАЛ

9.1 Дотоод аудит

Үйл ажиллагааны талбай хариуцсан ахлах ажилчид аюултай материалтай харьцдаг, хадгалдаг газруудад тогтмол үзлэг шалгалт хийнэ. Аюултай материалын үзлэг шалгалтанд байгаль орчны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн; байгаль орчны инженер; байгаль орчны ажилтан; химийн инженер: аюулгүй ажиллагааны ахлах ажилтан нарын аль нэг эсвэл хэд хэдэн нэр дурдсан албан тушаалтнууд оролцох бөгөөд химийн бодис, урвалжийн агуулах, түлш шатахуун цэнэглэх талбай, онцгой байдлын үед авах арга хэмжээнд ашиглагддаг тоног төхөөрөмж, аюултай хаягдал хадгалах газар гэх мэт үйл ажиллагааны өргөн хүрээтэй чиглэл, асуудлуудыг хамруулна.

Эдгээр үзлэг шалгалтаар илэрсэн бүх осол зөрчлийг БГК-ийн ЭМААБОМС-ийн шаардлагуудын дагуу мэдээлж тайлагнана.

9.2 Хөндлөнгийн аудит

БГК-ийн ЭМААБОМС-ийн аудитын хөтөлбөрийн хүрээнд түүнчлэн төслийн зээлдүүлэгчдийн зүгээс энэхүү төлөвлөгөөний биелэлтэд тодорхой давтамжтайгаар үнэлгээ хийнэ.

БГК-ийн үйл ажиллагаа нь ОУЦМИ-ийн Цианидын кодоод нийцэж буй эсэхэд гуравдагч байгууллагаас гурван жилд нэг удаагийн давтамжтайгаар хөндлөнгийн аудит хийнэ.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө		
Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 06.06.2016	Баримт бичгийн дугаар: Gatsuurt-HMP-Ver. 1	Хувилбар: 1

9.3 Бүртгэл хөтлөх

Аудит, үзлэг шалгалт, осол зөрчлийн бүртгэл хөтлөлтийг БГК-ийн ЭМААБОМС-ийн журмуудад заасны дагуу гүйцэтгэнэ.

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа:
06.06.2016

Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

Хавсралт А – Гацууртын болон Бороогийн уурхайнуудад ашиглагдах аюултай материалын бүртгэл

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа:
06.06.2016

Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

Бодисын нэр	Олон улсын бүртгэлийн дугаар	Химийн томъёо	Технологийн горим	Дундаж хэрэглээ
Натрийн цианид	143-33-9	NaCN	Үйлдвэрлэлийн салбар – Уусгалт (Идэвхжсэн нүүрстөрөгч бүхий шүлтийн уусмалаас алт гаргах арга)	0.2 кг/тн
Болсон шохой	1305-62-0	Ca(OH) ₂	Үйлдвэрлэлийн салбар – Хоргүйжүүлэх цех Уусмал дахь устөрөгчийн ионы төвшрүүлгийг тохируулах	0.04 кг/тн
Зэсийн сульфат	7758-98-7	CuSO ₄	Үйлдвэрлэлийн салбар – Хоргүйжүүлэх цех Хүчилд сул диссоциацлагдах цианидыг хоргүйжүүлэх катализатор	0.14 кг/тн
Натрийн метабисульфит	7681-57-4	Na ₂ S ₂ O ₅	Үйлдвэрлэлийн салбар – Хоргүйжүүлэх цех Цианидыг хоргүйжүүлэх	0.6 кг/тн
Төмрийн сульфат	10028-22-5	Fe ₂ (SO ₄) ₃	Үйлдвэрлэлийн салбар – Хоргүйжүүлэх цех Хүнцлийг хоргүйжүүлэх	0.21 кг/тн
Уусгалт хурдасгуур		Натрийн давс >96	Үйлдвэрлэлийн салбар – Хүндийн жингээр ялгаж авах алтыг уусгах катализатор	120 кг/сар
Идэвхжүүлсэн нүүрс Нүүрсээр цэнэглэх	7440-44-0	C	Үйлдвэрлэлийн салбар – Алт шингээгч	0.037 кг/тн
			Хий цэвэршүүлэх, чийг шингээгч	440 кг/жил
Магнафлок	79-06-01		Үйлдвэрлэлийн салбар – Умбуур бодис тунадасжуулагч	0.021 кг/тн
Давсны хүчил	7647-01-0	HCl	Үйлдвэрлэлийн салбар – идэвхжүүлсэн нүүрсийг цэвэрлэх	0.023 л/тн
Хүхрийн хүчил	7664-93-9	H ₂ SO ₄	Үйлдвэрлэлийн салбар – Хоргүйжүүлэх цех Уусмал дахь устөрөгчийн ионы төвшрүүлгийг тохируулах	0.017 л/тн
Натрийн борат	1303-96-4	Na ₂ B ₂ O ₇ x 10H ₂ O	Үйлдвэрлэлийн салбар – Алтыг хайлуулах	1.5 тн/жил
Натрийн карбонат	497-19-8	Na ₂ CO ₃	Үйлдвэрлэлийн салбар – Алтыг хайлуулах	700 тн/жил
Цахиурын нунтаг	7631-86-9	SiO ₂	Үйлдвэрлэлийн салбар – Алтыг хайлуулах	500 тн/жил
Сульфамийн хүчил	5329-14-6	NH ₂ SO ₃ H	Үйлдвэрлэлийн салбар – шигшүүр болон хонхорыг цэвэрлэх	3000 тн/жил
Идэмхий натри	1310-73-2	NaOH	Үйлдвэрлэлийн салбар – Десорбцийн уусмал	0.08 кг/тн
Антипрекс 11 (Antiprex)			Үйлдвэрлэлийн салбар – Усанд өнгөр тогтохоос сэргийлэх	0.004 л/тн

Аюултай материалын менежментийн төлөвлөгөө

Хэрэгжүүлж эхлэх хугацаа:
06.06.2016

Баримт бичгийн дугаар:
Gatsuurt-HMP-Ver. 1

Хувилбар: 1

Шатаасан шохой	1305-78-8	CaO	Үйлдвэрлэлийн салбар – умбуур бодис дахь устөрөгчийн ионы төвшрүүлгийг тохируулах	1.92 кг/тн
Цеолитоор цэнэглэх	1318-02-01		Хий цэвэршүүлэх ба чийг шингээгч	1760 кг/жил
Хатаагчаар цэнэглэх			Хий цэвэршүүлэх	880 кг/жил
Молекул шигшүүр				1500 кг/жил
Хатаах үйлчилгээтэй, идэвхжүүлсэн хөнгөн цагаан	1344-28-1	Al ₂ O ₃	Хий цэвэршүүлэх ба чийг шингээгч	3000 кг/жил
Магнийн хлорид	7786-30-3	MgCl ₂	Тоос намдаагч	5000 кг/жил
Ацетилен	7486-2	C ₂ H ₂	Засварын цехэд гагнуурын ажилд	320-480 м ³ /жил
Аргон	7440-37-1	Ar	Засварын цех	48-60 м ³ /жил
Пропан	7498-6	C ₃ H ₈	Засварын цехэд гагнуурын ажилд	210-280 кг/жил
Азот	7727-37-9	N ₂	Автотээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ, арчлалт	120-180 м ³ /жил
Азотын исэл	10024-97-2	N ₂ O	Хоргүйжүүлэх цехэд хүнцлийн хэмжээ тодорхойлох шинжилгээ	144-240 кг/жил
Хүчилтөрөгч	7782-44-7	O ₂	Засварын цехэд гагнуурын ажилд	900-1200 м ³ /жил
Циант устөрөгч	74-90-8	HCN	Суурилуулсан “хий илрүүлэгч”-ийн калибрац	515 л/жил